

2015 он дугаар 11

Английн хөтөлбөрийн шинэчлэл ба Япон хэлний сургалт

-Бага шатны боловсролд гадаад хэлийг заавал судлах хичээл болгож тусгах хандлагыг чухалчилж буй нь-

Фүкүшима Киёофүми Мүрада Ёоши

Түлхүүр үг: Англи, хөтөлбөрийн шинэчлэл, бага шатны боловсрол, гадаад хэлний боловсрол, хэлний бодлого

Хураангуй: Англид 2014 оны 9 сараас үндэсний шинэ хөтөлбөр хэрэгжиж эхэлсэн бөгөөд гадаад хэлний боловсрол дахь томоохон өөрчлөлт гэвэл бага ангийн 3 ангиас 6 ангид гадаад хэлийг заавал судлах хичээл болгон оруулж өгчээ. Гэхдээ бага боловсролын түвшинд гадаад хэлийг үзэх процесс нь анхандаа франц, герман, итали, хятад, испани, эртний латин эсвэл грек хэлээр хязгаарлагдаж байсан нь англи дахь япон хэлний сургалт ихээхэн сөрөг нөлөө үзүүлж ирсэн бөгөөд сүүлийн хөтөлбөрт 7 хэлний жагсаалтыг байхгүй болгосон ба хөтөлбөрийг боловсруулагдах хугацаанд Лондон дахь Япон сан соёлын төв ихээхэн чармайлт гаргажээ. Энэ удаа Английн хөтөлбөрийн шинэчлэлийн явцын Англи дахь япон хэлний боловсролтой холбоотой хэсгийн талаар өгүүлье.

1. Англид 2014 оны 9 сараас үндэсний шинэ хөтөлбөр хэрэгжүүлэхээр болсон нь 2010 оны 5 сард Хөдөлмөрийн намаас сонсерватив болон лебирал нам руу засгийн эрх шилжсэнтэй холбоотой юм. Бүлэг өөрчлөлтийн хүрээнд Их британийн гадаад хэлний боловсролд гарсан өөрчлөлт нь бага боловсролын 3-аас 6 ангид Key stage 2 буюу сургалтын 2 дахь шатлалаас эхлэн гадаад хэлийг заавал заахаар болсон явдал юм. Энэхүү өөрчлөлт нь өмнөх засгийн эрх барьж байсан Хөдөлмөрийн намын үед боловсруулсан 2002 оны төрөөс гадаад хэлний талаар баримтлах стратегид тодорхой дурдсан бөгөөд 10 гаруй жил саад тотгорын давсны эцэст хэрэгжихээр болсон байна. Энэхүү өгүүлэгийг бичих үед ч дунд ангийн төгсөлтийн шалгалтын шинэчлэл ид хийгдэж байсан ба ерөнхий сайд Камероны засгийн газраас явуулж буй энэхүү реформ нь Английн гадаад хэлний боловсролд томоохон өөрчлөлт шинэ орчинг авчирна гэж үзэж болно.

1. Эхлэл:

Өгүүлэлд хөтөлбөрийн шинэчлэлийн бэлтгэл эхэлсэн 2011 оны 1 сараас нийтэд зарласан 2013 оны 9 сар хүртэл өрнөлийг тусгахыг зорьсон болно. Гэхдээ гагцхүү хөтөлбөрийн талаарх мэдээлэлээр хязгаарласангүй. Хөтөлбөрийн шинэчлэлийн явцад Их британийн боловсролын яамнаас зохион байгуулсан зөвлөлдөх уулзалтаар / санал солилцох/ дамжуулан Английн засгийн газартай шууд тулж харилцах, Английн гадаад хэлний багш нарын холбоо, тус улс дахь элчин сайд нар, соёлын байгууллагуудтай санал солилцох, нүүр тулж уулзах зэргээр хөтөлбөрийн шинэчлэлд шууд бус замаар оролцсон хүний тайлан мэдээлэл гэж ойлгож болно. Энэхүү оролцоо нь сурагчдын япон хэлийг сонгоход шууд нөлөөлөл төдий бус суралцагчдын нийгэм дэх хэлний орчин, гадаад хэлний боловсролын сургалтын орчинд нөлөөлөх оролдлого бөгөөд өмнө нь япон хэлний сургалтанд нөлөөлж байсан оролцоонуудаас өөр

байж магадгүй. Гэхдээ өгүүлэлийг бичигч миний бие Япон сан гэсэн албан ёсны байгууллагын Англид япон хэлийг дэлгэрүүлэх байр суурь, япон хэлний сургалтын макро орчинг бий болгох гэсэн гол үйл ажиллагаа болон магадгүй энэ хүрээнд япон хэлний сургалтыг багтаах санал тавих гэхээсээ илүү анги танхмийн үйл ажиллагааны микро/дотоод/ түвшин, судалгаа, бодлого боловсруулагчид руу хандсан үйл ажиллагаа зэрэг макро түвшний оролцоог багтаасан гаргалгаа гэж ойлговол зүйд нийцнэ. Өгүүлэлийн гол агуулгын цаад санаа нь юуны өмнө английн хөтөлбөрийн шинэчлэлээр харагдаж байгаа ч, гадаад хэлний боловсролыг тойрсон орчингийн талаар “өнөөгийн бодит байдал” тусгах, улмаар хөтөлбөрийн шинэчлэл гэдэг нь орчинг өөрчлөх гэсэн дотоод үнэнг тэрхүү бий болсон процесстэй нь хамт бичихийг хүссэн. Эцэст нь орчинг өөрчлөх явцад Лондон дах Япон сан, соёлын төвөөс хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар өгүүлнэ. Түүнчлэн өгүүлэлийг бичих үед дунд шатны боловсролын шинэчлэл ч мөн хийгдэж байсан ч энэ удаа бага шатны боловсролын шинэчлэлд заавал судлах хичээл болгож оруулсан хүрээгээр хягаарлая.

2. Английн гадаад хэлний боловсролын систем ба өнөөгийн бодит байдал

2.1 Английн хэлний бүтэц, бүрэлдэхүүн

Юуны өмнө хөтөлбөрийн шинэчлэлийг хэрэгжүүлж буй Их британийн хэлний бүтэц болон гадаад хэлний боловсролын нөхцөл байдлыг өгүүлэхээс илүү хөтөлбөрийн шинэчлэлийг хийж ирсэн түүхэн үечлэлийг өгүүлмээр байна. 2009 оны тоо баримтаас үзэхэд Их британийн хүн ам 51 сая 810 мянга бөгөөд цагаан арьст бус хүн амын тоо 17.2% болсон нь 2001 оноос 13.2% байснаас эрс нэмэгдсэн байна. Лондонд 40.5%, Вермингэнд 36.7%, Манчестерт 30.1% зэрэг том хотуудад тус тус оршин сууж олон үндэсний хэв шинж бүхий бүтцийг бий болгож байна. 2011 оны хүн амын тооллогоор /Англи, Уэльс/ 92.3% англиар, 7.7% нь бусад хэлээр ярьдаг гэж дүн гарчээ. Английн төрийн өмчийн бага сургуулиудад эх хэл нь англи хэл бус хүүхдийн эзлэх хувь 18.7%, дунд сургуулиудад 14.3% байгаа ба Лондонгийн бага сургуулиудад бүр 48.1% болж өссөн ба Лондонгийн хойд дүүрэг Ньюхэм, Тавер Гамлетэд 75% давж байна. Лондонд 233-300 гаруй хэлээр ярилцах тохиолдол байна гэх нь бий. Гадаад хэлийг эзэмших байдлыг нь судалгаагаар авч үзвэл нийт Английн хувьд гадаад хэлээр чөлөөтэй ярьж чадна гэсэн хүмүүсийг хувиагаар бодоход 1 хэлээр ярьж чадна гэж 39%(ЕХ-54%), багадаа 2 хэл мэднэ гэж 14%(ЕХ-25%), огт мэдэхгүй 61%(ЕХ-46%) тус тус дүн гарсан байна. ЕХ-ний 27 улсын дунджаас доогуур тоо баримт юм. Англид судалгаанд оролцогчдын англи бус хэлтэй хүн буюу товчхондоо шилжин ирэгсдийн дотор эх хэл эсвэл англи хэлийг “наанадаж нэг хэл мэднэ” хариулсан хүн 12% байгаагаас үзвэл гадаад хэл мэддэг англи хүн буюу эх хэл нь англи хэлтэй хүн 39% ч хүрэхгүй байна гэж үзэж болно. Түүнчлэн 1-р гадаад хэлний “маш сайн” “сайн” “ердийн” гэсэн 3 түвшингээр асуухад ихэнх хүн буюу 59% нь “ердийн” гэж хариулж байгаа нь ЕХ-ноос хамгийн доогуур үзүүлэлт юм.

Мөн гадаад хэлний мэдлэгийн түвшингийн тухайд “ маш сайн”, “сайн”, “ердийн”гэсэн 3 хуваах бөгөөд олонх буюу 53% нь ердийн гэсэн түвшинг сонгож хариулсан нь ЕХ-ны 27 улсын дотор хамгийн бага үзүүлэлт болжээ.

2.2 Их британийн гадаад хэлний боловсролын тогтолцоо ба хөтөлбөр

2.2.1 Боловсролын систем

Их британийн боловсролын систем нь 6-5-2 буюу 5-11 нас хүртэл 6 жилийн анхан шатны боловсрол, 11-16 насны хооронд 5 жилийн буюу дунд шатны боловсролтой өөрөөр хэлбэл 11 жилийн албан боловсролтой юм.Их сургуульд элсэн суралцахыг хүсвэл 17-18нас хүртэл 2 жил ахлах сургуульд суралцах ба Японтой харьцуулбал 1 жилийн өмнө бага, дунд шатны боловсрол эхлэх бөгөөд 13 жил суралцсаны дараа Японтой адил 18 настайдаа дээд шатны сургуульд суралцдаг. Дээд боловсрол нь бакалавр 3 жил, магистр 1жил, докторын 3 жилийн стандарттай байдаг.

11 жилээ буюу албан боловсролоо дуусгаад GCSE гэсэн дунд шатны боловсролын ерөнхий шалгалтыг, 13 жил буюу ахлах сургуулиа дүүргээд GCE гэсэн боловсролын ерөнхий түвшин тогтоох дээд түвшний шалгалтыг тус тус өгөх ёстой.

Хүснэгт 1: хичээлүүдийн шалгалт болон гадаад хэлний хүрэх түвшинг харьцуулсан бөгөөд дээр дурдсан GCSE гэсэн дунд шатны боловсролын ерөнхий шалгалт нь 2001 онд Европын зөвлөлөөр батлагдсан CEFR стандартын A2-оос B1-д нийцэхээр, GCE гэсэн боловсролын ерөнхий түвшин тогтоох дээд түвшний шалгалт нь AS/A/AEA- стандартын B2 түвшинд нийцүүлсэн болно. Гэхдээ энэхүү дүйцүүлэл нь ямар хэмжээний нарийн зөв шалгууртай эсэх нь тодорхойгүй бөгөөд ямартай япон хэлний сургалттай холбоотой шалгуур нь бодит байдалтай нийцгүй зүйл олон байна гэж бодож байна. Гадаад хэлний сургалтын хүрэх үр дүнг 2.3-т өгүүлэх болно.

Хүснэгт 1

Үндэсний боловсролын стандарт	Үндэсний хөтөлбөр	Срөнхий боловсролын чадамж	Гадаад хэлний чадварын үечлэл	Европын холбооны стандарт
Элсэх эрхийн түвшин	1,2,3	Элсэх эрхийн 1,2,3	Бэлтгэл шат	A1
1-р түвшин	4-6	GCSE –н суурь чадвар	Бэлтгэл-анхан түвшин	A2
2-р түвшин	7-	GCSE –н дээд чадвар	Дунд шат	B1
3-р түвшин		AS/A/AEA стандартын чадамж	Ахисан түвшин	B2
4-6 р түвшин		бакалавр	Туршлага дадал зүйн	C1
7 ба 8 түвшин		Магистр, доктор	Төгс дээд	C2

2.2.2 Үндэсний хөтөлбөр ба гадаад хэлний сургалт

М.Тетчирийн засгийн эрх барьж асан 1988 онд боловсролын шинэчлэлийн хуулиар үндэсний хөтөлбөрийг бий болгон, суурь боловсрол олгож буй төрийн болон нийтийн сургуулиудад нийтлэг, заавал заах ёстой хичээлүүдийг тусгайлан нэрлэж, цөм хичээлд англи хэл, тоо, байгалийн ухааныг, суурь хичээлд түүх, газар зүй, технологи, дуу хөгжим, гоо зүй, биен тамир, гадаад хэл (KS3, KS4) байхаар тогтжээ. Тони Блейрын засгийн үед 2004 онд анги дэвшин суралцагсдын хувь багассантай уялдан дунд шатны боловсролыг эргэн харж, сурагчдын хүсэл сонирхолд нийцүүлсэн KS4 дэх хөтөлбөрийг уян хатан байдлаар зохицуулахаар болжээ. Тухайн үед гадаад хэл болон технологийн хичээлүүд нь заавал судлах хичээл бус сонгон судлах хичээл болж, харин KS3–н 3 жилийн хугацаанд л гадаад хэлний хичээлийг заавал судлахаар байна.

Энэ хугацаанд гадаад хэлийг хөгжүүлэх бодлого эрчимжин Nuffield сангийн 2000 оны судалгаагаар зөвхөн англи хэл судлах нь хангалттай бус юм, гадаад хэлний боловсролын талаар төрийн стратеги бодлого зайлшгүй шаардлагатай байгааг дэвшүүлсэн. Дээрх судалгааг үндэслэн 2002 онд гадаад хэлний стратегийг боловсруулж, 1-рт хэлний сургалт боловсролын чанарыг дээшлүүлэх, 2-рт шалган үнэлэх тогтолцоог нэвтрүүлэх, 3-рт гадаад хэл сурагчдын тоог нэмэгдүүлэхээр дэвшүүлсэн байна. 1-рт 2010 он гэхэд KS2 шатанд гадаад заах ба дунд шатны сургалтанд хийх шинэчлэлийг гүнзгийрүүлэх, 2-рт GCSE, GCE зэрэг английн боловсролын ерөнхий шалгалтуудыг CEFR стандарттай уялдуулахыг тусгасан гадаад хэл сурах орчин, шатлал/ хүүхэд, сургууль, гэр бүл/ -г бий болгох, 3-рт тасралтгүй боловсрол, дээд боловсрол, ажил мэргэжлийн дадлагын хөгжлийг зарлан тунхагласан байна.

1-3 аас үзэхэд амьдралын бүхий л хүрээг хамарсан гадаад хэлний сургалтын төлөвлөгөөг боловсруулж чадсан гэж хэлж болно. Бага шатны боловсрол дахь гадаад хэлний сургалтын тухайд 2005 онд K2 түвшинд заах гадаад хэлийг 2010 он гэхэд заавал судлах хичээл болгоход анхаарч ирсэн ч, 2010 онд Камероний 3Г байгуулснаар хойшлогдсон бөгөөд 2014 оны 9 сараас л хэрэгжүүлэхээр болжээ.

2.3 Гадаад хэл суралцагчдын тоо ба үр дүн

Өмнө дурдсанчилан, 2002 оноос Англид төр засаг нь стратегийн үүднээс гадаад хэлийг дэмжиж ирсэн ч тодорхой үр дүн гараагүй. Жишээ нь дунд шатны боловсролоо дүүргээд өгөх GCSE–н гадаад хэлний шалгалт өгөгчдийн хувь хэмжээ 2002 онд 78%-с доошилж, 10 жилийн дараа 2012 онд 40% хүртлээ буурч, үр дүн санасан хэмжээнд хүрсэнгүй. /Board and Tinsley 2014:20/

Хүснэгт 1: ЕХ комиссоос явуулсан дунд шатны боловсрол эзэмшиж буй сурагчдын 1-р гадаад хэлний эзэмшсэн байдлын талаарх 13-16 насыг хамруулсан судалгаа юм. / FR, DE, NL / гэсэн нь англи, франц, герман, голланд хэлийг илэрхийлж байгаа бөгөөд судалгаанд хамрагдсан хэлнүүд нь хаалтанд

дотор оруулсан байна. Бельги улс нь франц, герман, голланд гэсэн 3 хэлний бүст хуваагддаг болохоор англи, франц хэлээр судалгаанд хамрагдсан байх жишээтэй. Их британийн хувьд Англи /UK, ENG /, хамгийн их шалгалт өгөгчид 15 насныхан франц хэлээр хамрагджээ. Үр дүн нь A1–д хүрсэнгүй pre A1-н түвшинд 30%, A1 нь 48% нийлээд судалгаанд хамрагдсан орнуудын дотор хамгийн өндөр үзүүлэлт болжээ. 3 жил гадаад хэл заалгасан бөгөөд судалгааг явуулсан үед 2011 оны нийт оролцогчдын 40% нь GCSE шалгалтыг өгөгчид байсан ба хамгийн их оноо авсан эхний хүүхдүүдийн 40% нь гадаад хэлийг тасралтгүй үзэж судалсан гэж бодоход ч GCSE шалгалтын A2-B1 түвшинг хангасан хүүхдийн хувь хагасаас хэтрэхгүй гэж ойлгож болно.

Хүснэгт1: Дунд шатны боловсрол эзэмшиж буй сурагчдын 1-р гадаад хэлний эзэмшсэн байдал

Швед(англи хэл)	pre-A1-1%, A1-6%, A2-11%, B1-25%, B2-57%
Мальт (англи хэл)	pre-A1-2%, A1-7%, A2-9%, B1-22%, B2-60%
Голланд (англи хэл))	pre-A1-2%, A1-14%, A2-18%, B1-36%, B2-36%
Эстони (англи хэл))	pre-A1-7%, A1-20%, A2-12%, B1-41%, B2-41%
Словени (англи хэл)	pre-A1 30%, A1-22%, A2 18%, B1-25%, B2-29%
Хорват (англи хэл)	pre-A1-11%, A1-23%, A2 19%, B1-24%, B2-23%
Грек (англи хэл)	pre-A1-23%, A1-23%, A2 16%, B1-22%, B2-26%
Бельги гер(франц хэл)	pre-A1-20%, A1-29%, A2-22%, B1-21%, B2-19%
Болгар (англи хэл)	pre-A1-20%, A1-48%, A2 13%, B1-16%, B2-19%
Бельги франц (англи хэл)	pre-A1 30%, A1-29%, A2-16%, B1-16%, B2-19%
Португал (англи хэл)	pre-A1-20%, A1-33%, A2-16%, B1-16%, B2-15%
Испани (англи хэл)	pre-A1-22%, A1-35%, A2- 13%, B1-14%, B2-13%
Польш (англи хэл)	pre-A1-24%, A1-34%, A2-17%, B1-15%, B2-10%
Бельги голл(франц хэл)	pre-A1-16%, A1-41%, A2-21%, B1-15%, B2-7%
Франц (англи хэл)	pre-A1-31%, A1-40%, A2-15%, B1-9%, B2-5%
Их британи анг(франц хэл)	pre-A1 30%, A1-48%, A2-13%, B1-7%, B2-2%

2.4 “Өнөөгийн бодит байдал” дүгнэлт

Их британийн хэлний бүрэлдэхүүн, гадаад хэлний сургалтын нөхцөл байдлыг өгүүлэе. Хотжих процесс, жилээс жилд олон үндэстний хэл, соёл нь нэвтэрч байгаа ба цаашдаа ч зогсохгүй гэдэг нь ойлгомжтой юм. ЕХ бүс нутагт шилжин ирэгсдийн тоо эрчимтэй явагдаж буй өнөөгийн нөхцөлд гадаад хэлний сургалтын хэрэгцээ дотооддоо ч гадаадад ч нэмэгдэж байгаа ба Английн ард иргэд гадаад хэлний мэдлэг дутагдалтай байгаа талаар 21 зуун гарснаар л асуудал болгон тавьж ирсэн. Үүнийг засаж залруулах гэж 2002 оноос засаг

барьж байсан хөдөлмөрийн намаас хэрэгжүүлсэн бодлого 10 ч жилийн нүүрийг үзсэн бөгөөд, өнөөгийн засгийн газар анхан шатны боловсролд гадаад хэл заах нь зайлшгүй юм гэж үзэж байгаа ба юутай ч Их британи дах гадаад хэлний сургалтын хөгжил урагшилсаар байна. Гэхдээ хэрэглэх орчин, сургалтын үр дүнг харахад эсрэг дүр төрх харагдаж байна. Абэ /2011/ дээрх шалтгааны нэг тал нь гадаад хэлний мэдлэг чухал гэж үзэж байгаа ч бодит байдал дахь үйл явц ялгаатай, нийцээгүй байна гэдгийг аж үйлдвэрийн салбар, Их британийн ЗГ, сургалт явуулж буй байгууллагуудын жишээгээр дурдсан байна. Аж үйлдвэрийн салбарын тухайд ажилд орох хүмүүст гадаад хэлний мэдлэг нь бусад мэдлэг чадвартай (уншиж бичих, багаар ажиллах чадвар, мэргэжлийн ур чадвар) харьцуулахад үнэлгээ доогуур байна. ЗГ-ын хувьд 2004 оны гадаад хэлний сонголт нь гадаад хэлний сургалтанд, хэрэгцээнд сөрөг байдлаар хандаж байгаа нь, сургалтыг явуулж байгууллагуудын тухайд багшид ч, сурагчдад ч “ гадаад хэл сурах нь хэцүү” гэсэн ойлголт байдаг ба GCSE шалгалтын үнэлгээ нь сурагч төдийгүй тухайн сургуулийг үнэлэхэд хэрэглэдэг Их британийн хувьд сурагч, сургууль аль аль нь GCSE-д орсон гадаад хэлний хичээлээс зайлсхийх гэсэн хандлагыг зогсоож чадахгүй байна. “Зөвхөн англи хэлтэй байхад хангалттай бус” гэсэн Английн гадаад хэлний сургалтын идэвх тухайн ойлголтын өөрчилж чадахгүй байгаагийн эсрэгээр глобальчлалын эрчимжилт, бусад улсын англи хэлний боловсролын амжилтаас үүдэн урагш ахихгүй нөхцөл байдал үүсчихээд байна.

Гэхдээ энэ нь “Англи хэл байхад л хангалттай” гэсэн нөхцөл байдлыг өөрчилсөн зүйл гэсэн утга биш билээ. Эсрэгээр дээр өгүүлсэн дотооддоо, олон талт хэл, соёл нь нэвтэрч буй Английн тухайд нийгмийн хамааралыг тунгаан ухаарсан үедээ л гадаад хэлний сургалтын явцад харилцан биенээ ойлгох, өөр бусдын соёлыг хүндлэх гэсэн хэрэгцээ сонирхол нэмэгдэж ирдэг гэж боддог. Яагаад гэвэл улс орны дотооддоо янз бүрийн үндэстэн, соёлын нэгдэл бүхий Англи улс өөр бусдын соёлын талаар ойлгох мэдлэг, хүндлэх байдал дутмаг байгаа нь нийгмийн тогтворгүй байдал, салан тусгаарлах үзэл түгээмэл учраас тэр буй заа. Нөгөө талаар ЕХ-ны бүс нутагт шилжин суурьшигчид ихээр нэмэгдэн, ЕХ-ны орнуудын хэлийг нэгэнтээ гадаад хэл гэж үзэхгүй болсонтой холбоотой байх. ЕХ дах англи хэлний үүрэг роль өндөр, англи хэлний бус бүс нутагт суралцах, ажиллах боломж нэмэгдэх явцад “англи хэл байхад л хангалттай” гэсэн бодол хувь хүний үйлдлийн хүрээг хязгаарлаж байгаа нь гарцаагүй бизээ. Ийм нөхцөл байдал дах гадаад хэлний сургалтын орчинг хүлээн авсан өнөөгийн Английн эрх баригчид хэрхэн яаж хөтөлбөрийн шинэчлэлийг явуулах болоо. Анхан шатны боловсролын гадаад хэлийг сургалтанд заавал судлахаар оруулах гэж буй Английн хөтөлбөрийн шинэчлэлийн явц, агуулга болон JFLO хөтөлбөрийн шинэчлэлийн хамаарлыг дор өгүүлнэ.

3. “Сургалтын орчинд хийсэн өөрчлөлт”: Хөтөлбөрийн шинэчлэл ба JFLO- хандлага

3.1 Хөтөлбөрийн шинэчлэлийн үндсэн чиглэл

2011 оны 1сард Их британийн боловсролын сайд Майкл Горф консерватив либерал намуудын эвслийн ЗГ-н үндсэн 3 зарчим болох Эрх, эрх чөлөө,

хариуцлага, шударга ёсонд нийцүүлж Английн үндэсний хөтөлбөрийг эргэн харах болсноо зарлав.

- Хэрхэн хичээлийн бүтцийг бий болгож заах вэ гэсэн багшийн эрх чөлөөг нэмэгдүүлэх
- Бүх сургуулийн хөтөлбөрт хөгжүүлэн, оюуны өндөр чадвартай сурагчаас хөгжлийн бэрхшээлтэй тусгай боловсрол шаардлагатай сурагч хүртэл сурагч нэг бүрийн сонирхолыг харгалзсан боловсролын тодорхой шатлалаар өөртэй итгэлтэй, үр дүндээ хүрэх гэсэн эрмэлзлэлийг бүхий мэдлэгийг өсвөр үеийнхэнд олгоно.
- Үндэсний хөтөлбөрийн агуулга нь хүүхдийн сурах арга барил, сурах агуулгатай холбоотой мэдлэгийг тусгасан дэлхийн хамгийн тэргүүний боловсролын хөтөлбөрт дүйцүүлэх
- Боловсролын үе шатлалаар хүүхдүүд юу сурч мэдэж авсан байх ёстой вэ гэдгийг эцэг эх нь ойлгож, хүүхдүүдийнхээ боловсролыг дэмжин оролцдог болох

Хөтөлбөрийн шинэчлэлийн онцлогийг нэгтгэн хэлбэл 1. Сургуулийн эрх чөлөө, эрх мэдлийг нэмэгдүүлэх 2. Хүүхдийн олон талт онцлог руу чиглэсэн хандлага 3. Өндөр мэдлэгийн түвшинд хүргэх гэсэн ойлгоход хялбар шийдэлтэй юм

3.2 Хөтөлбөрийг шинэчлэх явц

Хөтөлбөр батлагдах үйл явцыг JFLO-н оролцоотой нэгтгэн авч үзье. Их британийн боловсролын яам хөтөлбөрийн шинэчлэх явцад төслөө танилцууахийн хамт хэд хэдэн шалтгаанаар зөвлөгөөн зохион байгуулсан. Тухайлбал анхан шатны боловсрол олгоход гадаад хэлийг заавал оруулах тухайд маргаан үүсч байгаа гэсэн үүднээс санал солилцсон байна.

	Он сар	Товч агуулга	Баримт бичгийн нэр
1	2011.01.20-4.14	Тоо баримттай үндэслэл бүхий мэдээлэл солилцох	National Curriculum Review- Call for Evidence
2	2011.12.19	Мэргэжилтнүүдээс мэдээдэл авах	The Framework for the National Curriculum A report by the Expert Panel for the National Curriculum review
3	2012.07.6-09.28	Зөвлөгөөн 1	Making Foreign Languages compulsory at Key Stage 2
4	2012.11	Зөвлөгөөн1-н үр дүнг мэдээлэх	Making Foreign Languages compulsory at Key Stage 2 Consultation Report: Overview
5	2012.11.16-12.16	Зөвлөгөөн 2	Consultation on(1)the draft Order making Foreign Languages statutory for key Stage 2; and(2)a proposal to require schools teach one or more of seven Languages at key Stage2
6	2013.02	Зөвлөгөөн2-н үр дүнг	Consultation Report

		мэдээлэх	Foreign Languages at Key Stage 2
7	2013.02.07	Шинэ үндэсний хөтөлбөрийн төсөл	The National Curriculum in England Framework document for consultation
8	2013.02.07-04.16	Зөвлөгөөн 3	Reform of the National Curriculum in England
9	2013.07	Зөвлөгөөн3-н үр дүнг мэдээлэх	Reform of the National Curriculum in England Report of consultation conducted February-April 2013
10	2013.07	Зөвлөгөөн 3-н талаар ЗГ хариулт	Reform of the National Curriculum in England Government response to the consultation conducted February-April 2013
11	201307.08	Шинэ үндэсний хөтөлбөрийн төсөл/ засвар/	The National Curriculum in England Framework document
12	2013.07.08-08.08	Зөвлөгөөн 4	National Curriculum Review; new programmes of study and attainment targets from September 2014
13	2013.09	Зөвлөгөөн4-н үр дүнг мэдээлэх	Reforming of the National Curriculum in England Summary report of July to August 2013 consultation on the new programmes of study and attainment targets from September 2014
14	2013.09.11	Шинэ үндэсний хөтөлбөрийн / хэвлэгдсэнээр/	The National Curriculum in England:framework for key stages 1to4

1.Тоо баримттай үндэслэл бүхий мэдээлэл солилцох зөвлөгөөн

2011 оны 1 сарын 24-с 4-р сарын 14 хооронд Боловсролын яам “Тоо баримттай үндэслэл бүхий мэдээлэл солилцох уулзалт “-г зохион байгуулж 5763 асуулт хариулт авсан байна. Гадаад хэлийг үндэсний хөтөлбөрт багтах хичээл гэдэг 81 % нь зөвшөөрч дэмжсэн байна. Зөвшөөрсөн хариултын дотор боловсролын ямар шатанд заавал судлах хичээлээр оруулах вэ гэдэгт KS3 гэж 93% , KS2 82% нь хариулсан байна.

2. Мэргэжилтнүүдээс хөтөлбөрийн шинэчлэлтэй холбоотой мэдээлэл тайлан авах

2011 оны 12 сард Дем тэргүүлсэн мэргэжлийн багуудын тайлан нийтлэгдэн гарав. Уг тайланд KS2-н сүүлийн хагасаас KS4 шат хүртэл гадаад хэлийг үзэж судлах боломжтой, KS2 –н эхний хагаст гадаад хэл зайлшгүй оруулах талаар дахиж нухацтай бодох шаардлагатай гэж харзсан байна.

3. 4. 1-р зөвлөгөөний хэрэгжилт, үр дүнгийн тайланг нийтлэх

2012 оны 6 сард Боловсролын яам KS2 шатанд гадаад хэлийг заавал судлах хичээл болгох үндсэн чиглэлээ нийтэд мэдээлэв. 2012 оны 7 сарын 6-с 9 сарын 28 хүртэл KS2 шатанд гадаад хэлийг оруулах эсэх талаар бага боловсролын сургуульд ямар гадаад хэл заах төлөвлөгөөтэй вэ гэсэн асуудлаар санал зөвлөгөөн явууллаа. 318 хариулт ирсний KS2 шатанд оруулахыг дэмжсэн 289 санал буюу 92%, ямар гадаад хэл заах вэ гэсэн асуултанд хамгийн их нь франц хэл 59, испани хэл 24, герман 16, польш, урду, бенгаль, еврей 2, итал хэл 7, хятад хэл 3, гэсэн санал өгчээ.

5. 2-р зөвлөгөөнийг зохион байгуулах

2012 оны 11 сарын 16-с 12-р сарын 16-ны хооронд дахин KS2 шатны гадаад хэлний боловсролын талаар санал зөвлөгөөн хийв. Уг шатанд франц, герман, итали, хятад, испани, эртний хэл/грек, латин/ хэлнүүдээс нэгээс дээш хэл заах ЗГ бодлогыг илэрхийлж, энэ талаар санал нийлж буй эсэх талаар асуулт хариулт авсан. Энэ чиглэлийн дагуу бага боловсролын байгууллагууд нэр бүхий 7 хэлнээс сонгох болсон учир япон хэлний хувьд боломж багасах байдал үүссэн. Дээрх нөхцөл байдалд JFLO япон хэл заа буй багш нар, судлаачид, японы хөрөнгө оруулалттай байгууллага, ААН мөн бусад японтой холбоотой хүмүүсийг олон талаар хамтарч ажиллахыг уриалж, 7 хэлний жагсаалтыг байхгүй болгох, япон хэлийг заах шалтаан бүхий жишээ хариултууд боловсруулсан бөгөөд хариултаа өгөхийг уриалжээ. Бодсоноос олон хариулт дэмжлэгүүд ирсэн бөгөөд гол гол жишээ хариултыг дор дурдая.

Дээрх нэр бүхий 7 хэлний жагсаалтаас сонгогдоогүй хэл нь нийгэмд эзлэх чухал шинж байхгүй гэсэн алдаатай сэтгэгдлийг бага насныханд өгч болзошгүй учир эсрэг байр суурьтай байна. Их британийн сургуулиуд нэгэнтээ гадаад хэлний олон талт соёлыг хүлээн авч, сургууль, багш нар, бүс нутгууд өөр өөрийн өвөрмөц онцлогийг бий болгосон тул цаашид эдгээр боломжоо ашиглах ёстой.

Япон хэл нь анхан шатан дах эзэмших явц харьцангуй хялбар гэсэн онцлогтой, Япон сан болон бусад байгууллагын дэмжлэгтэйгээр Англи дах дэмжин туслах тогтолцоо сайжирч байна. Мөн Япон улсаас эдийн засагт нөлөөлөх чухал байр суурь болон олны мэддэг соёл урлагийн төрлүүд зэрэг үл тоомсорлож болохгүй хэрэгцээ байгаа юм. Заах хэлийг зөвхөн 7 хэлнээс сонгох гэсэн тогтолцоонд оруулах нь дээрх хэрэгцээ бүхий япон хэлийг сурах боломжийг алдаж болзошгүй байдалд хүргэнэ.

6. 2-р зөвлөлдөх уулзалтын үр дүнгийн тайланг хэвлэх

2013 оны 2 сард дээрх 2-р зөвлөлдөх уулзалтын дүнгийн тайланг нийтлэгдэж, ЗГ үндсэн чиглэл ч өргөн баригдсан. 2-р зөвлөлдөх уулзалтанд

нийт 601 санал ирж, KS2 шатанд заах ёстой хэлний тухай асуулгад 562 хариулт ирсэн бөгөөд үүний 61% буюу 343 хариулт ЗГ-ын төслийн эсрэг байв. 562 хариултын дотор KS2 шатанд япон хэлийг багтаах нь зүйтэй гэсэн санал 13% буюу 67 болон өссөн нь япон хэлийг дэмжих аян явуулсантай холбоотой юм.

Гэхдээ, дээрхтэй адил үр дүнгээс үл хамааран энэхүү уулзалтын дүнд тулгуурлаж нийтлэгдсэн ЗГ үндсэн чиглэл нь 1-рт 2014 оны 9 сараас KS2 шатанд гадаад хэлний боловсролыг заавал оруулах, 2-рт франц, герман, итали, хятад, баруун европын хэлнүүд, эртний хэлнүүд дотроос нэгийг заах боловч дээр чөлөөтэйгээр хэлийг нэмж сонгон судалж болно гэсэн байна. Энэ нь жагсаалтан дах 7 хэлнээс нэгээс дээш заах гэсэн бодит хандлага болон 2012 оны 7-р сараас 9 сарын 1-р зөвлөгөөнөөр бага боловсролын байгууллагад заах төлөвлөгөөтэй гэсэн хариулсан хэлнүүдийг тусгахыг оролдсон байна. Түүнчлэн Европын голлох хэлнүүд дээр хятад, латин, эртний грек хэл багтаж байгаа шалтгааныг тэмдэглэсэн ба хятад улс нь эдийн засгийн хувьд чухал улс ба латин, эртний грек хэл нь олонх орчин үеийн хэлнүүдийн суурь болдог гэсэн тайлбар хийсэн байна.

7. Үндэсний шинэ хөтөлбөрийн сургалтын программын төслийг нийтэд мэдээлэх, 8. 3-р зөвлөлдөх уулзалтыг явуулах

2013 оны 2 сарын 7, шинэ хөтөлбөрийн хичээл нэг бүрийн программыг зарлах тэр мөчид 3-р зөвлөгөөнийг зохион явуулсан. Энэхүү программын төслийн тухайд KS2 шатан дах гадаад хэлийг заавал заахаар оруулах, франц, герман, итали, хятад, баруун европын хэлнүүд, хятад, латин, эртний грек хэлний дотор” нэг хэлийг сурагчид хангалттай ахиц гарахаар төвлөрөн заах шаардлагатай” гэжээ. KS3 шатан дах орчин үеийн гадаад хэлийг үргэжлүүлэн заавал заах, хичээлийн программын төсөлд KS3 дах гадаад хэлний сургалтын талаар “KS3 шатанд дээрх аль ч хэлийг зааж болно, KS2 шатанд хуримтлагдсан суурь мэдлэг дээр тулгуурлахгүй бол болохгүй” хэмээн KS2 болон KS3 хооронд сургалтын шилжилтийн талаар ч тусгасан байна.

Энэ 3-р зөвлөгөөний тухайд ч JFLO нь япон хэлний сургалтыг дэмжих саналыг эрчимтэй авахыг холбогдох хүмүүс, байгууллагад хүссэн. Цуврал зөвлөгөөн болон дагалдан гарах бичих баримт хэмжээ нэмэгдэн, өрнөлийг гүйцэхэд хэцүү байсан учир JFLO нь зөвлөгөөний үр дүнгийн талаарх удирдамжуудыг нэгтгэн холбогдох хүмүүст өгсөн юм. Улмаар шинэ хөтөлбөрт нийт зөвлөгөөний дүнг тусгаж чадаагүй, энэ төсөл нь энэ чигээр батлагдвал япон хэлний сургалтанд ихээхэн саад тотгор, сургалтын хүрээ хумигдах нь санааг зовоон KS2-с бусад боловсролын шат дах япон хэлний сургалтанд муу нөлөө үзүүлж болзошгүй гэх мэт зүйлүүдийг холбогдох хүмүүст нь дамжуулсан байна. Мөн Их британи дах хэл, соёлын олон хэв шинжийг хадгалах байр суурь, Их британийн хувьд эдийн засаг, бизнес салбарт япон улс чухал байр эзэлдэг болох, Их британи дах япон хэлний сургалтыг дэмждэг тогтолцоо боловсронгуй болж байгаа зэрэг янз бүрийн талаас нь шалтгааныг жишээ татан, холбогдох хүмүүст зөвлөгөөний саналыг өгөхийг эрчимжүүлэв. JFLO нь боловсролын яамны хөтөлбөрийн шинэчлэлийг хариуцсан хэлтэсийнхэнтэй шууд санал

солилцох боломжийг бий болгох, улс төр, засаг захиргааны холбогдох хүмүүстэй ч идэвхтэйгээр ажиллав.

9. 3-р зөвлөгөөний дүнгийн тайлан бичиг, 10. ЗГ хариуг нийтлэв

2013 оны 7-р сарын 8-д 3-р зөвлөлдөх уулзалтын дүнгийн тайлан бичиг болон уг зөвлөгөөнд илгээсэн ЗГ-ын илгээлт нийтлэгдэв. 3-р зөвлөгөөн шинэ хөтөлбөртэй бүхэлд нь холбоотой 17312 санал ирсэн ба үүний дотор сургалтын программтай холбоотой 3682 санал байжээ. Гадаад хэлний сургалтын талаар KS2 шатанд гадаад хэлний сургалтыг нэвтрүүлэх тухайд санал нэгдэж байгаа хэдий ч, олон санал нэр бүхий хэлний жагсаалтыг өөрчлөх ёстой, улмаар еврей, япон хэл зэргийг жагсаалтад оруулахыг дэмжсэн, эртний гадаад хэлэнд хандах эргэлзээтэй саналууд ч байв.

11. Шинэ үндэсний хөтөлбөрийн шинэчилсэн найруулгыг нийтэлсэн

9. болон 10.-ын зөвлөгөөний дүнгийн тайлан бичиг, ЗГ-ын илгээлттэй зэрэгцэн мөн өдөр шинэ үндэсний хөтөлбөрийн төслийн засаж шинэчилсэн хэвлэлийг олон нийтэд танилцуулсан байна. Үүнд KS2 шатан дах гадаад хэлний талаар “ аль ч орчин үеийн гадаад хэл, эртний гадаад хэлнүүдийг зааж болно, сурагчид нэг хэлийг чанартай сурахыг эрмэлзэх ёстой.” гэсэн ойлголтыг өөрчлөн, 7 хэлний жагсаалт бүхий тодорхойлолтыг хаслаа. Мөн KS3 тухайд “ аль ч орчин үеийн гадаад зааж болно, KS2 шатанд заалгасан гадаад хэлний хичээлд суурилах ёстой ч, сурагч сурагч сурсан гадаад хэлээ үргэжлүүлэн сурсан ч болно, шинээр гадаад хэл сурсан ч болно” гэж KS2 болон KS3 шатанд нэг гадаад хэлийг заалгахгүй байсан ч болно гэж нэмж оруулжээ.

12. 4-р зөвлөгөөнийг зохион явуулах, 13. Үр дүнгийн тайлан бичгийг нийтлэх

Үүний дараа буюу 2013 оны 7 сарын 8-наас 8-р сарын 8-ны хооронд шинэ үндэсний хөтөлбөрийн агуулгыг батлахтай холбогдон 4-р зөвлөгөөнийг явуулж, гадаад хэлний тухайд эцсийн зөвлөгөөнийг хийсэн. 2013 оны 9-р сарын 11-д нийтлэгдсэн 4-р зөвлөгөөний дүнгийн тайлан бичиг, ЗГ-н илгээлтээс үзэхэд нийт 750 санал гарч, шинэ хөтөлбөрийн төслийн шинэчилсэн засварын гадаад хэлний талаар 103 тайлбар ирсэн ба түүний дотор 36% нь KS2 шатанд аль ч хэлийг заах боломжтой гэсэн өөрчлөлтийг сайшаасан байна. Түүнээс гадна 15% нь KS2-с KS3 шатанд шилжих шилжилтийг хамгийн болсон гэж үзсэн ба 10% нь KS2 шатны 4 жилийн хугацаанд нэг хэл сурахгүй болсныг дэмжиж, 14% нь шинэ хөтөлбөрийн гадаад хэлний талаар илүү нарийвчилсан зүйл дутаж байна гэж санал өгчээ. JFLO-с ч хэлний сонголтын чөлөөт байдал нэмэгдэж байна гэж санал нийлсэн байна.

14. Шинэ үндэсний хөтөлбөрийг баталж, олон нийтэд танилцуулсан нь

Дээрх өрнөлүүдийг дамжсаны эцэст 2013 оны 9-р сарын 13-нд үндэсний шинэ хөтөлбөр батлагджээ.

3.3 Гадаад хэлний боловсролын сургалтын хөтөлбөрийн агуулга, онцлог

Шинэ үндэсний хөтөлбөр дэх гадаад хэлний боловсролын сургалтын хөтөлбөрийн талаар авч үзье. Гэхдээ хэлний боловсролын агуулгаас илүү

өнөгийн ЗГ-ын явуулж байсан бодлогын онцлогыг өмнөх 2007 оны хөтөлбөртэй харьцуульж үзэхийг чухалчиллаа.

3.3.1 Гадаад хэлний боловсролын хөтөлбөрийн бүтцийн онцлог

Гадаад хэлний боловсролын сургалтын хөтөлбөр нь KS2, KS3-н нийтлэг зүйл “сургалтын зорилго”, “хүрэх түвшин”-с гадна KS тус бүрийн “сургалтын агуулга” гэсэн хэсгээс бүрдэнэ. Дээр дурдсанчилан шинэ хөтөлбөрийн өөрчлөлтийн чухал зүйл бол 1. Сургуулийн чөлөөт байдлыг нэмэгдүүлэх, 2.хүүхэд нэг бүрийн онцлогт нийцүүлэх, 3. Өндөр түвшин хүргэх, үүнийг биелүүлэхийн тулд хичээлийн хөтөлбөрийг цомхон тодорхой болгох, мөн илэрхийлэлүүдийг хялбарчилахаар болжээ. Үүний үр дүнд шинэ хөтөлбөрийн гадаад хэлний сургалтын хөтөлбөр нь дөнгөж 5 хуудас бүхий цомхон болсон байна. 2004 онд хэвлэгдсэн хөтөлбөр нь 48 хуудастай, 2007 оных 13 хуудастай байсантай харьцуулбал нөлөөлөл нь илүү том юм. Өмнөх хөтөлбөрт хүрэх түвшин нь чадвар тус бүрт 8 хуваагдаж байсан бол энэ удаа байхгүй болсон байна. Ингэж цомхон, чадварын түвшин тус бүрээр хуваадаг байсныг хассан нь сургуулийн чөлөөт байдлыг нэмэгдүүлэх, хүүхэд нэг бүрийн онцлогт нийцүүлэхэд чиглэсэн. Гэхдээ 3. Өндөр түвшин хүргэх гэсэн зорилгын тухайд шинэ хөтөлбөрт тодорхой тусгаагүй юм. 3 дах удаагийн санал солилцох зөвлөгөөний эцэст гаргасан санамж бичигт “ч” сургалтын хөтөлбөр нь хүүхдүүдийн хувьд хангалттай дуртай сонирхолтой түвшинд хүч сорьж болдоггүй юм уу гэсэн асуулгад 738/22%/ нь өөрийн хүссэн түвшинд хүрэхэд хангалттай, 1276/39%/ нь өөрийн хүссэнээр тодорхой түвшинд хүрэхэд хангалтгүй, 1297/39%/ хэлж мэдэхгүй байна гэсэн тоо гарсан нь хийсвэр ойлгоход түвэгтэй байдал үүсгэж байгаа юм. Мэдээж гадаад хэлний боловсролын KS2 шатанд заавал судлахаар оруулсан нь мэдлэгийн түвшинг ахиулах найдвар тавьж байгаа болов уу. Боловсролын яамны эцсийн зорилгыг мэдэж авахад өнөөгийн хэрэгжүүлж буй шалгалтын шинэчлэлийн үр дүнг хүлээх нь дээр болов уу.

3.3.2 Гадаад хэлний боловсрол дах сургалтын хөтөлбөрийн агуулга дах онцлог

Агуулга дах өөрчлөлтийг авч үзье. Өмнөх хөтөлбөртэй харьцуулахад “нэг хэл судлахыг эрхэмлэх” “сонгодог хичээлүүд”, “утга зохиолиудыг унших” практик чадвар суулгах” “сургалтын хэрэглэгдэхүүн ашиглах” зэрэг багтсан болно. ” практик чадвар суулгах” “ сургалтын хэрэглэгдэхүүн ашиглах” гэсэн агуулга нь өмнөх хөтөлбөр ч байсан бөгөөд хэмжээний хувьд багасгаж чухал гэсэн зүйлүүдийг нь үлдээжээ. “Нэг л хэлийг судлах” “уран зохиолын бүтээлүүдтэй танилцах” “сонгодог хичээл” гэсэн агуулгууд оруулж ирсэн шинэ хөтөлбөрийн онцлог юм. Өмнөх хөтөлбөрөөс хасагдсан зүйл нь “ глобальчлал ба ялгаа бүхий соёлыг ойлгох”, “нийтийн хэл- олон хэлний соёлын хүндэтгэх” гэсэн агуулгууд байв. Өмнөх хөтөлбөрт гадаад хэлний болосрол ба хувь иргэний боловсролын харилцан хамааралыг оруулж байсан бол энэ удаа суурь хэлний мэдлэгийг тусгаж өгсөн. Жишээ нь өмнөх гадаад хэлний боловсролын чухал шинж гэсэн утгаар “сурагчид бусад улсын соёл, хүмүүсийн талаар судлаж харьцуулан өөрийн соёл, нийгмийг таних” гэсэн зорилгыг эрхэмлэж байв.

Өнөөгийн ЗГ нь заавал судлах хэлэнд 7 хэлийг багтаасан жагсаалтын эсрэг Европын ба дэлхийн хэл гэсэн ойлголтыг бий болгосон байна. Өмнөх хөтөлбөрт гадаад хэлний боловсролоор олон талт нийгмийг бүрдүүлэхэд чухал гэж үзэж байсан бол энэ удаа сурган хүмүүжүүлэх, нэг хэл голлосон хэлний чадавхыг дээшлүүлэх гэсэн хувь хүнд хандсан өөрөө өөрийг судлах, хөгжүүлэх чадамжуудыг зорилго болгожээ.

3.4 Сурах орчны өөрчлөлт

Шинэ хөтөлбөрийг боловсруулах явц, агуулгын талаар авч үзлээ. Шинэ хөтөлбөрөөр хэлний хэрэглээний чадварын бодитой үр дүнг чухалчилсан нь өнөөгийн ЗГ-с Англичуудын гадаад хэлний мэдлэг бага байгаатай уялдуулсан бодлого болов уу. Нэг хэлийг тасралтгүй сурах гэсэн хэлний орчны өөрчлөлт нь Европ орнуудын хэлтэй харьцуулахад сургалт явуулж буй байгууллагын цөөн тоотой япон хэлний сургалтын хувьд сөрөг үр дүнтэй гэж үзэхээр байна. Гадаад хэлний боловсролын тасралтгүй шинжийг чухалд тооцсон өнөө үед шинээр гадаад хэлний сургалтыг эхлүүлэх анхан шатны сургуулиуд нь бүс нутгийн дунд шатны сургуулиудад зааж байгаагүй хэлийг сонгон авахад түвэгтэй байдал үүсэх нь даамжиггүй. Өнөөдөр дунд шатны сургуулиудад япон хэлний сургалт явуулж байгаа сургуулийн хувьд ч тухайн бүс нутгийн бага сургуульд япон хэл заалгаж байгаагүй хүүхдийн тоо нэмэгдвэл япон хэлний сургалтанд хүндрэлтэй байдал үүсэх болов уу. Иймэрхүү орчны өөрчлөлтийн үед япон хэлний сургалтыг хэрхэн зохицуулах вэ гэсэн шаардлага урган гарах болов уу.

4. Хөтөлбөрийн шинэчлэлтэй холбоотойгоор Лондон дах Япон сангийн (JFLO) явуулах бодлого

4.1 Хөтөлбөрийн шинэчлэлийн явцад JFLO-гийн оролцоо нь Английн боловсролын яамнаас зохион байгуулсан зөвлөлдөх, санал солилцох уулзалт болон төрөл бүрийн сувгаар / интернэт сүлжээ, зөвлөгөөнд судалгаа, мэдээлэлээр хангах/ өөрийн саналыг хүргэсэн явдал юм. JFLO нь гол төлөв япон хэлний багш нар, судлаачидтай шууд харьцан зөвлөгөөнд оролцохыг уриалж байлаа. Хөтөлбөрийн онцлог нь нэг хэлийг тасралтгүй судлах гэсэн чиглэл байсан бөгөөд үүнд хэрхэн нийцсэн бодлого барих вэ гэсэн асуудал байв.” Яагаад япон хэл гайхамшигтай вэ- Why Japanese is sugoi ! “ гэсэн веб хуудас хүртэл нээсэн бөгөөд Англид Японы хөрөнгө оруулалттай 1300 компаний 130000 ажлын байр бий болгосон нь ЕХ-н дах хамгийн өндөр үзүүлэлт, түүнчлэн 2012 онд Японоос Их британид оруулсан хөрөнгө оруулалтын мөнгөн дүн 41,6 тэрбум фаунд болсон нь Азийн орнуудаас хамгийн өндөр буюу удаах байранд орсон Гонконгоос даруй 4 дахин их, мөн япон хэлний сургалтыг дэмжих тогтолцоо ямар вэ гэдгийг тус тус уг хуудаснаас олж мэдэх боломжтой байв.

4.2 Хөтөлбөр батлагдсаны дараах оролцоо

Шинэ хөтөлбөр батлагдсанаар KS2 түвшинд Япон хэлийг сонгох боломж бий болсон хэдий ч 4 жилийн туршид KS2-н япон хэлний сургалтыг дэмжих систем JFLO-д байсангүй. 2013 оны 7 сард 7 хэлний жагсаалт хасагдахтай хамт яаралтай төлөвлөгөө боловсруулж “ сурах бичиг боловсруулах” “ багшийг дэмжих” “ татаас тусламж” зэрэг Английн бага

боловсролын сургуулиуд руу чиглэсэн япон хэлний сургалтыг дэмжих төлөвлөгөөг баталжээ.

“Сурах бичиг боловсруулах” –н тухайд албан ёсны хичээл гэдэг утгаар япон хэлний хичээлд хэрэглэх боломжтой 4 жилийн заах аргын төсөл /SOW-scherme of Work/ хийгдэн, уг төслийн ажлын хүрээнд Англи хүүхдүүдийн хувьд дасал болоогүй “Япон орон” “Япон хэл” гэсэн онцлогыг ашиглан газар зүй, урлаг, дуу хөгжим зэрэг хичээлийн агуулгыг оруулж өгсөн.

“Багшийг дэмжих”-н хувьд бага боловсролын багш нарыг хамааруулж Япон хэл зааж байгаагүй багш нарт япон хэлний сургалт, япон хэл мэддэг багш нарт заах аргын сургалтыг тус тус хэрэгжүүлэв.

“татаас тусламж”-д гол төлөв бага сургуулийн удирдлага, япон хэлний тэнхмийн эрхлэгч нар хамрагдан хилийн чанад ах сургалтын баазыг бэхжүүлэхэд тэднийг урьж идэвхтэй оролцуулах ажил хийгдсэн.

5. Төгсгөл

Дээр дурдсан хөтөлбөрийн шинэчлэл хийгдэж буйтай уялдан гадаад хэлний боловсролын өнөөгийн орчин, хөтөлбөрийн явц, агуулга гэсэн орчны өөрчлөлт, түүнтэй нийцүүлж явуулах бодлогын талаар макро, микро түвшинг тойрсон япон хэлний сургалтын талаарх өөрийн ажиглалтыг бичлээ. Энэ 4 жилийн хугацаанд өгүүлэлийг миний бие болон английн гадаад хэлний багш нар шинэ ЗГ-н баталсан бичиг баримттай танилцах их ажилд дарагдан ирсэн. Дээрх ЗГ бодлогын баримт бичиг нь зарим хүний хувьд үүрэг оролцоо нэмэгдэж байгаа ч нөгөө талаар олон япон хэлний багш нарын хувьд “ажил багасах хумигдах, цалин хөлс буурах, ажилгүйдэл зэрэг хохиролтой асуудал үүснэ. Энэ удаагийн хөтөлбөрийн шинэчлэлийн талаар бичигч миний бие Англи гэсэн өөр улсын ЗГ бодлогыг өөрчлөх гэсэн бус үнэндээ өөрийн орны ЗГ бодлогыг өөрчлөхөд гол зорилгоо болгосон. Английн ЗГ бодлогын бичигт заасан “Япон хэлийг дэмжих” зорилго ажилгүй болж болзошгүй япон хэлний багш нарт чиглэсэн юм. Гэхдээ дан ганц “Япон хэлний багшийн ажлаа алдана гэсэн шалтгаанаар хөтөлбөрт япон хэлийг суулгасан гэвэл учир дутагдалтай. Заавал судлах 7 хэл бүхий жагсаалтад япон хэлийг багтаахыг хүссэн нь амиа бодсон юм шиг сонсогдож магадгүй. Хөтөлбөрийн шинэчлэлийн явцад JFLO нь хувийн эрх ашиг, сэтгэгдэл дээр үндэслэсэн тайлбарыг нийгмийнх ньбайдалтай уялдуулж дахин үнэлэх, ойлгуулах, бодлогод оруулан тайлбар хийх зэргээр илүү сайн ятгах сэнхрүүлэх замаар оролцсон гэж хэлж болно. Япон сангийн зүгээс япон хэлний сургалтанд ном сурах бичиг боловсруулах, багшийн мэргэжил дээшлүүлэх зэргээр оролцож байгаа ч, глобальчлагдаж буй өнөө үед өөрийн орны хэл соёлыг түгээх олон орны төр засгийн бодлогын өрсөлдөөн ширүүс ч байгаа үед цаашдаа төр засгийн түвшинд ажиллах шаардлагаа нэмэгдүүлэх чухал гэсэн дүн гарч байна. Хилийн чанад дах япон хэлний сургалтын өнөөгийн байдал олон орны гадаад хэлний бодлого болон японы өөрийн улсын хэлийг түгээх бодлоготой нийтлэг тал, цаашилбал хоёр орон аль алинд нь суралцах боломжтой суралцагчдийн цаашдын ирээдүй, багш нарын амьдрал зэрэг янз бүрийн сонирхол дээр оршиж байна. Энэ удаагийн хуримтлуулсан туршлага гэвэл нэг талын ашиг сонирхолын харилцаа ч, ашиг

сонирхол бүхий талуудтай уулзалт ярилцлагыг хийх явцад нийтлэг олон зүйлүүд байдгийг олж мэдэж авсан болов уу.

2013 оны 9 сарын 18-д Английн боловсролын төрийн нарийн бичгийн орлогч Элвис Торрес Лондон хийсэн илтгэлдээ хөтөлбөрийн шинэчлэлд Япон сангийн оролцоог жишээ татан” энэ л бидний хүсэж байсан зүйл, товчхондоо хөтөлбөрийн шинэчлэл нь сургуулиуд дах инновацийг өдөөсөн бодит жишээ юм хэмээн өгүүлжээ.

Энэ удаагийн хөлбөрийн шинэчлэл Английн япон хэлний сургалт хумигдах, буурах магадлал их байсан тул бичигч миний бие ч айдастайгаар янз бүрийн салбарын, түвшний хүмүүстэй ярилцаж, санал бодлоо солилцох бодлого барисан. Тухайн явцдаа энэхүү үйл ажиллагаа нь япон хэлний сургалтын хөгжүүлэх нэг үйл ажиллагааны нэг хэсэг байж, япон хэлний сургалтын бодит байдлыг тайлбарлан бичих шаардлагатай юм гэдгийг мэдэрсэн. Энэ бол Хөтөлбөр гэдэг нь ирээдүйн улсын болон ард иргэдийн дүр төрхийг илэрхийлдэг ойлголттой, боловсролыг явуулж буй яг тухай газрын нийтлэг зүйлийг үгээр зуучлах үйл юм. Цаашилбал тухайн бүс нутаг дахь JFLO шиг япон хэл суралцагч, багш нарын бодит нүүр царайг таньж мэдсэн үндсэн дээр засгийн бодлогын түвшинд оролцох анхан шатны буюу энгийн байгууллагад боломж их бий болдог гэсэн бодол төрсөн.